



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛГ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.01.10 № 01

Метро барих төслийн санхүүжилтийн
талаар

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод метро барих төслийг 2024-2028 онд хэрэгжүүлэх шийдвэрийг Засгийн газрын хуралдаанаас гаргаж, метроны төслийн гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй тендерээр сонгон шалгаруулах болсон. Түүнчлэн зураг төсөл болон техник, эдийн засгийн үндэслэл батлагдсаны дараа Засгийн газраас санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр мэдээлсэн болно.


Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн миний бие дээрх төслийн талаар дараах асуулт тавьж байна. Үүнд:

1. Метро барьж, байгуулах төслийн нийт санхүүжилт болон төсвийг хэрхэн урьдчилан тооцсон талаар;
2. Засгийн газар тус төслийн санхүүжилтийг ямар хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлэхээр төлөвлөж буй талаар дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Н.ГАНИБАЛ

2024000001